



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/106

Бор-Өндөр

**Газар ашиглалтын зориулалт
өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгох журам”-ын 8.10 дахь хэсэг, Хэнтий аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Засаг даргын тамгын газрын эзэмшлийн газрын зориулалтыг эзэмшигчийн хүсэлтийг харгалзан, нэгдүгээр хавсралтад заасны дагуу өөрчилсүгэй.
2. Газар ашиглалтын зориулалт өөрчлөгдсөн газрын мэдээллийг захирамжийн дагуу Газрын кадастрын мэдээллийн санд тусгахыг Газрын даамал /Т.Эрдэнэзаяа/-д зөвшөөрсүгэй.
3. Газар эзэмшүүлэх гэрээнд заасан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээг жил бүр дүгнүүлж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ГАДЪЯАБИЛЭГТ

Сумын Засаг даргын 2024 оны
дугаар сарын 12-ны өдрийн
А/10 дугаар захирамжийн 1-р хавсралт

Газар эзэмшигч болон газрын мэдээлэл

Газар эзэмшигчийн						
д/д	Хуулийн этгээдийн нэр	Регистр	Газрын			
			Хэмжээ /м ² /	Нэгж талбарын дугаар	Шинэчилсэн зориулалт	Эзэмших хугацаа /жил/
1	Засаг даргын Тамгын газар	9075399	1105.0	2322003422	2207: Үйлчилгээтэй орон сууц	13
					1-р баг, Боржигоны зам, 100а тоот	